

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2022 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ
2023 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 18-НЫ ӨДӨР /ЛХАГВА ГАРАГ/-ИЙН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Хэлэлцсэн асуудал	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-10
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	11-53
	1.Дэд хорооны даргыг сонгох тухай	11-12
	2.“Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай” Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хоорондын гэрээний төсөл /Засгийн газар 2023.01.04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/	12-17
	3.“Иргэний болон арилжааны хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх тухай” Монгол Улс болон Бүгд Найрамдах Куба Улс хоорондын гэрээний төсөл /Засгийн газар 2023.01.04-ний өдөр ирүүлсэн, зөвшилцөх, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ/	17-18
	4.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	18-23
	5.Казиногийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	23-42
	6.Бооцоот таавар, хонжворт сугалааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	42-46
	7.Бооцоот морин уралдааны тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.12.26-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	46-52
	8.Монгол Улсын шүүхийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2023.01.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	52-53

ХУРААНГУЙ ТЭМДЭГЛЭЛ

Дөрөв.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2022.11.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга П.Сайнзориг, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Д.Цолмон, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах мэргэжилтэн Б.Анхбаяр, Дотоодын цэргийн штабын дарга Р.Чингис, мөн штабын Харуул хамгаалалтын хэлтсийн дарга Н.Мөнх-Итгэл, ахлах офицер Г.Галдандулжа, Цагдаагийн ерөнхий газрын Захиргааны удирдлагын газрын дарга Л.Нямдаваа, мөн газрын Хуулийн хэлтсийн дарга И.Батчулуун нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Мажигсүрэн, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт П.Хулан нар байлцав.

Төслийн талаарх ажлын хэсгийн гаргасан тусгайлсан саналыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн зүйлүүдтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Ц.Мөнхцэцэг нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнх-Оргил, Дотоодын цэргийн штабын дарга Р.Чингис нар хариулж, тайлбар хийв.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Ц.Мөнх-Оргил: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 7.3 дахь хэсгийн “, энхийг дэмжих, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох” гэснийг хасаж, мөн хэсгийн “байна” гэснийг “байж болно.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 9.3 дахь хэсгийн “18-аас” гэснийг “15-аас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 6
Бүгд: 13
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 9.4 дэх хэсгийн “түүнийг” гэсний дараа “энэ хуулиар олгосон эрхийн хүрээнд” гэж нэмж, мөн хэсгийн “энэ хугацаанд” гэснийг хасаж, мөн заалтын 9.5 дахь хэсгийн “даргад” гэсний дараа “тушаалаар” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 36.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.7.Дотоодын цэргийн алба хаагчийг албан үүргээ гүйцэтгэж байх үед албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг нэгжлэг хийх тохиолдолд тухайн алба хаагчийг шууд захирах даргад мэдэгдэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 5
Бүгд: 13
61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 38.4 дэх хэсгийн “үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг ашиглах, мэдээлэл дамжуулах,” гэснийг хасаж, мөн зүйлийн “болно” гэснийг “болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “тогтоосон” гэсний дараа “улс орны нийгэм, эдийн засаг, стратегийн” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын “улсын онц чухал” гэсний дараа “болон шаардлагатай бусад” гэж,” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 4.1.1 дэх заалтын “аль нэг” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Найруулгын саналаар санал хураалт явуулав.

1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын “8.1.13” гэсний дараа “, 8.1.14” гэж нэмж, төслийн 4 дүгээр зүйлийн “33.1.1.12” гэснийг “33.1.12” гэж өөрчилж, төслийн 2 дугаар зүйлийн “тус тус” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8

Татгалзсан: 5

Бүгд: 13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгийн гаргасан зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Ц.Мөнх-Оргил: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 15 дугаар зүйлийн 15.35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтын “нэвтрэгчид” гэснийг “нэвтрэх эрх бүхий хүнд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Нэг.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Ц.Мөнх-Оргил: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “6.33” гэснийг “6.62” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	5
Бүгд:	13

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийн “6.33” гэснийг “6.62” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн:	9
Татгалзсан:	4
Бүгд:	13

69.2 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 15 цаг 31 минутад хэлэлцэж дуусав.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Дөрөв.Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Ажлын хэсгийг нь оруулаарай. Хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийн танилцуулгыг ажлын хэсгийн гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир танилцуулна. Сандаг-Очир гишүүний микрофоныг өгөөрэй.

Ц.Сандаг-Очир: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2012 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг ХЗБХ 22 оны 12 дугаар сарын 20-ны өдөр, чуулганы нэгдсэн

хуралдаанаар 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдрүүдэд хэлэлцэж анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороонд шилжүүлсэн билээ. Хуулийн төслүүдийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлтийн төсөл боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр, гишүүдээр Улсын Их Хурлын гишүүн Ганбат, Дэлгэрсайхан, Мөнх-Оргил, Сандаг-Очир нар ажиллалаа.

Хуулийн төсөлд улсын онц чухал объектын хамгаалалтын найдвартай, аюулгүй байдлыг хангах чиг үүргийн хүрээнд цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг уялдуулах, дотоодын цэргийн алба хаагчдыг төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагын алба хаагчдын нэгэн адил алба хаасан хугацааг тооцохдоо ажилласан 1 жилийг 1 жил 3 сараар тооцож нийгмийн баталгаагаар хангаж, тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэхээр, мөн штабын дарга нь дотоодын цэргийн командлагчийг түр эзгүйд түүнийг энэ хуулиар олгосон эрхийн хүрээнд орлох бөгөөд гаргасан шийдвэрийнхээ хууль зүйн үр дагаврыг өөрөө хариуцахаар дотоодын цэргийн алба хаагчийг албан үүргээ гүйцэтгэж байх үед албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг нэгжлэг хийх тохиолдолд тухайн алба хаагчийг шууд захирах даргад мэдэгдэх, улсын онц чухал объектын хамгаалалтын найдвартай, аюулгүй байдлыг хангах, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор хамгаалуулагч байгууллагын нэмэлт санхүүжилт авч болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална гэж зарчмын зөрүүтэй 12 саналыг бэлтгэлээ.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулга болон зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Ц.Мөнх-Оргил: Сандаг-Очир гишүүнд баярлалаа. Ажлын хэсгийг танилцуулъя. Сайнзориг Хууль зүй, дотоод хэргийн яамны ТНБД, Чингис Дотоодын цэргийн штабын дарга, бригадын генерал, Цолмон Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга, Анхбаяр Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын бодлогын хэрэгжилтийг газрын ахлах мэргэжилтэн. Нямдаваа ЦЕГ-ын захиргааны удирдлагын газрын дарга, цагдаагийн хурандаа, Батчулуун ЦЕГ-ын Хуулийн хэлтсийн дарга, цагдаагийн хурандаа, Мөнх-Итгэл Дотоодын цэргийн штабын орлогч, харуул хамгаалалтын хэлтсийн дарга, дэд хурандаа ийм ажлын хэсэг байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-т Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцье. Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэгдүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүн байна уу? Байхгүй байна. Ажлын хэсгээс нэг санал нэгдүгээр зүйл дээр 5 санал оруулсан байгаа. Нэг бүрчлэн хэлэлцээд явъя.

1.Төслийн 1 дүгээр зүйлийн 2 дахь заалтын 7.3 дахь хэсгийн “, энхийг дэмжих, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаанд оролцох” гэснийг хасаж, мөн хэсгийн “байна” гэснийг “байж болно.” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг. Санал

хураалт. Асуулттай гишүүд байна уу? Кнопоо дараарай. Энх-Амгалан гишүүний микрофоныг өгье. Дараа нь Мөнхцэцэг гишүүн асуултаа асууна. Энх-Амгалан гишүүн.

Б.Энх-Амгалан: Дотоодын цэргийн тогтолцоо, албан хаагчийн эрх зүйн байдлыг сайжруулах, тэнд нийцүүлж цалин хангамжийг нэмэгдүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, үр бүтээлтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэх гээд хуулийн зорилго бол яах вэ ойлгомжтой л байна. Тэгэхдээ дотоодын цэргийн байгууллага чинь улсын онцгой объектуудыг л хамгаалдаг ийм байгууллага шүү дээ. Онц чухал болон бусад улсын объектуудыг хамгаалдаг. Тэгээд ийм байгууллага ингээд төрөлжсөн цэргийн байгууллагад дэмжлэг үзүүлнэ, энхийг дэмжинэ. Энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох гээд байгаа юм уу? Террорист үйлдлийг сөрөх үйл ажиллагаанд оролцох нэгжтэй байна энэ тэр гээд. Ийм юмнуудыг бол би хасах нь зөв гэдэг дээр санал нэг байна. Энэ бол тийм байх ёстой.

Хоёр дахь нь энэ дээр чинь нөгөө дотоодын цэргийн анги орлогч нь генерал цолтой байна гээд нөгөө цол орж ирээгүй биз? Цол хэргэм энэ тэр чинь сүүлийн үед ингээд тэр нь ийм цолтой, энэ нь ийм цолтой байна гээд хуулиар цол олгодог ингээд болчих гээд байх юм. Энэ чинь Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн асуудал байгаа шүү дээ. Тийм учраас энэ юмнуудыг. Тэгээд дээр нь ингээд байгууллага болгон нэг ийм мөнгөн урамшуулал авдаг боллоо доо энэ сүүлдээ төсөв даах юм болов уу даа. Өмнө нь бас ингээд л бас л ингээд л тэдэн жил ажиллавал ингэнэ гээд л Онцгой байдлынхан ингээд л аваад явсан. Бас л ингээд л 30 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг 5 жил тутамд олгоно л гэнэ. Тэгээд л ингээд л хуулиараа бид нар ингэж юмнууд олгож явсаар байгаад Монгол Улсын эдийн засаг энэ дотоодын нөөц бололцоо энэ төсөв өөрөө даах юм бол уу даа. Энэ дээр бас нэг та нар маань бодоорой л гэж хэлэх гэж байгаа юм. Өөр юмгүй.

Ц.Мөнх-Оргил: Баярлалаа. Эхний асуулт дээр та бол саналыг дэмжиж байна гэж санал хэллээ. 2 дахь асуулт дээр Сайнзориг дарга тэр төсөвтэй холбоотой юман дээр санал хэлэх үү. Хариулт өгөх үү? Чингис дарга хариулах уу?

Р.Чингис: Энх-Амгалан гишүүний асуултад дотоодын зэрэг штабын дарга, бригадын генерал Чингис хариулъя. Ямар ч гэсэн бид нар энэ тооцоо гаргасан юм гишүүнээ. Тэгээд энэ дээр тооцоо гарахад өнөөдрийн байдлаар бид нар яг ирэх жил, дараа жил гэсэн ямар ч байсан энэ 30 сарын тэтгэвэр тэтгэмжийн асуудал ерөөсөө яригдахгүй. Төсөвт ямар нэгэн дарамт учруулахгүй байгаа. Яагаад гэвэл өнөөдрийн байдлаар бид нар яг энэ аймгийн төвөөс зайтай тэр оршин суугаа газрыг нь бүгдийг нь асуудлыг нь шийдээд тэнд нь байлгавал 5 жилийн дараа энэ нэг асуудал шийдэгдэнэ. Асуудал шийдэхдээ нэг цөөн тооны улсууд байгаа. Тийм болохоор бид нар энийг тооцоолоод ямар нэгэн төсөвт дарамт учруулахгүй гэсэн тооцоо гаргасан байгаа. Нэг хориод нэг гучаад л хүн байгаа л даа бид нар жилд. Тийм.

Ц.Мөнх-Оргил: Мөнхцэцэг гишүүн асуулт асууя.

Ц.Мөнхцэцэг: 7.3 дээр нөгөө төслийн ажлын хэсгээс оруулсан санал дээр асуулт байна л даа. Дотоодын цэргийн байгууллага бол Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ гээд. Тэгэхээр энэ сүүлийн үед энэ олон улсын болон бүс нутгийн нөхцөл байдлын үед бас террорист үйл ажиллагаа гарахгүй гэх эрсдэл байхгүй байгаа. Тэгэхээр дотоодын цэргийн нэг функц нь энэ террорист үйлдлийн эсрэг сөрөг тусгай ажиллагаа байж болохоор харагдаад байгаа

юм. Тэгэхээр ажлын хэсэг дээр яагаад энийг авчихсан бэ? Энэ дээр хариулт авмаар байна.

Ц.Мөнх-Оргил: Энэ сая нэгдүгээр зүйлийг ярьж байна уу? Энэ дээр ийм л үг байгаа шүү дээ. Засгийн газраас оруулж ирсэн төсөл нь бол бид нар энэ дээр ажлын хэсэг дээр өөрчлөөгүй. Дотоодын цэргийн байгууллага нь Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргийг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд, өөрөөр хэлбэл одоо хийж байгаа ажлынхаа хүрээнд хэрэгжүүлэх төрийн цэргийн байгууллага мөн гэсэн. Биш одоо тэр тагнуул, терроризм эд нар руу бол тусдаа асуудал. Одоо бол онцгой чухал объектын хамгаалалт хариуцаж байгаа шүү дээ. Тэр чинь үндэсний аюулгүй байдлын үйл ажиллагааг чиглэлийг хангаж байгаа үйл ажиллагаа мөн үү гэвэл мөн. Тэр хүрээндээ ажлаа хийж байгаа төрийн цэргийн байгууллага гэсэн санаа. Тэр террорист үйлдэл энэ тэр гэдгийг хаслаа гэдэг та санал хэлж байгаа юм байна шүү дээ. Тэрийг бол ингэж нарийсгаж тусгах шаардлагагүй гэж үзэж байгаа юм. Угаасаа байх ёстой байгууллагууд нь байвал, одоо оролцож байгаа байх тийм ээ? Тийм. Асуулт асууж, хариулт авч дууслаа. Ажлын хэсгээс оруулсан саналын томъёоллыг дэмжье гэсэн саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт болж байна шүү гишүүдээ. 53.8 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2 дахь санал хураалт. Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 9.3 дахь хэсгийн “18-аас” гэснийг “15-аас” гэж өөрчлөх. Асуулттай гишүүд байна уу? Байхгүй байна. Санал хураалт. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 53.8 хувийн саналаар ажлын хэсгийн санал дэмжигдлээ.

3.Төслийн 1 дүгээр зүйлийн 5 дахь заалтын 9.4 дэх хэсгийн “түүнийг” гэсний дараа “энэ хуулиар олгосон эрхийн хүрээнд” гэж нэмж, мөн хэсгийн “энэ хугацаанд” гэснийг хасаж, мөн заалтын 9.5 дахь хэсгийн “даргад” гэсний дараа “тушаалаар” гэж нэмэх. Асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Ажлын хэсгээс гарсан санал саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 61.5 хувийн саналаар ажлын хэсгийн санал дэмжигдлээ.

4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 8 дахь заалтын 36.7 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“36.7.Дотоодын цэргийн алба хаагчийг албан үүргээ гүйцэтгэж байх үед албадан саатуулах, цагдан хорих, баривчлах, албан тасалгаа, унаа болон биед нь үзлэг нэгжлэг хийх тохиолдолд тухайн алба хаагчийг шууд захирах даргад мэдэгдэнэ гэсэн томъёолол байгаа юм. Томилолттой холбогдуулж асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ дээр чинь өөрсдөө мэдэгдээд тэгээд орных нь хүнийг заавал томилно гэсэн санаа байсан. Тэр нь байгаа юу? Тэгж ойлгож байгаа юм уу тийм ээ. 61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.Төслийн 1 дүгээр зүйлийн 9 дэх заалтын 38.4 дэх хэсгийн “үйл ажиллагаанд шинжлэх ухааны ололт, орчин үеийн техник, технологи, мэдээллийн сүлжээг ашиглах, мэдээлэл дамжуулах,” гэснийг хасаж, мөн зүйлийн “болно” гэснийг “болох бөгөөд холбогдох журмыг Засгийн газар батална.” гэж өөрчлөх. Асуулттай гишүүд байна уу? Байхгүй байна. Ажлын хэсгийн саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. 61.5 хувийн саналаар ажлын хэсгийн санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Байхгүй байна. Энэ дээр ажлын хэсгээс нэг санал хураалт санал болгож байгаа.

Төслийн 2 дугаар зүйлийн “4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалтын “тогтоосон” гэсний дараа “улс орны нийгэм, эдийн засаг, стратегийн” гэж, 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтын “улсын онц чухал” гэсний дараа “болон шаардлагатай бусад” гэж,” гэснийг хасах. Асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Санал хураалт явуулъя. 61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Ажлын хэсгээс нэг санал хураалтыг санал болгож байгаа. Төслийн 3 дугаар зүйлийн 1 дэх заалтын 4.1.1 дэх заалтын “аль нэг” гэснийг хасах гэж байгаа юм. Санал хураалт явуулъя. 61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Найруулгын санал байна. Төслийн 1 дүгээр зүйлийн 4 дэх заалтын “8.1.13” гэсний дараа “, 8.1.14” гэж нэмж, төслийн 4 дүгээр зүйлийн “33.1.1.12” гэснийг “33.1.12” гэж өөрчилж, төслийн 2 дугаар зүйлийн “тус тус” гэснийг хасах. Санал хураалт явуулъя. 61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан санал асуулт, санал хурааж дууслаа.

Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Тусгайлсан саналын томъёолол байхгүй байна.

Хуулийн төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье, байхгүй байна. Тусгайлсан санал хураалт байхгүй.

Хуулийн төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Тусгайлан санал гаргаагүй. Найруулгын саналыг сая нэг санал байна. 2 дахь санал нь. Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл, заалтын дугаар, эшлэлийг нийцүүлж өөрчлөх. Санал хураалт. 61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ. Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье. Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэгдүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье, алга. Байна. Ажлын хэсгээс нэг санал хураалтыг санал болгож байгаа.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1 заалтын 15 дугаар зүйлийн 15.35 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2.1 дэх заалтын “нэвтрэгчид” гэснийг “нэвтрэх эрх бүхий хүнд” гэж өөрчлөх. Санал хураалт явуулъя. 69.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Байхгүй байна. Тусгайлан санал хураалт байна. Энэ биш үү? 2дугаар зүйл чинь.

3 дугаар зүйлтэй холбогдуулан санал асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн

төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг сая хэлэлцчихсэн биз дээ. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцье. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн нэгдүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Нэг саналтай. Төслийн 1 дүгээр зүйлийн 1 дэх заалтын 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “6.33” гэснийг “6.62” гэж өөрчлөх. Санал хураалт явуулъя. 61.5 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Байхгүй байна. Нэг санал хураалт байгаа. Төслийн 2 дугаар зүйлийн “6.33” гэснийг “6.62” гэж өөрчлөх. Санал хураалт. 69.5 хувь 2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Хуулийн төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд нэрсээ өгнө үү? Байхгүй байна. Энэ дээр санал хураалт байхгүй юм байна тийм ээ. Санал хураалт байхгүй юм байна. Хэлэлцэж дууслаа. Хуулийн төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Байхгүй байна. Ажлын хэсэг санал гаргаагүй байна. Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. Дотоодын цэргийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Байнгын хорооны санал байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир танилцуулна. Дараагийн асуудалдаа оръё. Ажлын хэсэг явж байж болно. Горимын санал Дэлгэрсайхан гишүүн.

Б.Дэлгэрсайхан: Энэ саяны хуулийг анхны хэлэлцүүлгийг ингээд хэлэлцсэнтэй холбогдуулж чуулган завсарлах дөхөж байгаа ойртчихсон байгаа учраас энийг анхны хэлэлцүүлгээр нь эцэслэн батлах ийм горимын санал гаргаж байгаа юм. Анхны хэлэлцүүлэг дээр зарчмын зөрүүтэй саналын томъёоллууд хураагдсан учраас анхны хэлэлцүүлгээр батлах бололцоогүй юм байгаа юм. Дараагийн асуудалд оръё.